



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

2026 оны 5 дугаар сар

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2026 оны 06 сарын 20
Улаанбаатар хот

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт

Тодорхойлолт*

Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА

Л.БАЯНЗУЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГЭРЭЛНЯМ

БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.НЭМЭХЖАРГАЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

¹ Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. АЧАА ТЭЭВЭР	6
1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР	7
БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР	8
2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА	8
2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	8
БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР	9
3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА	9
3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ	12
БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР	13
4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА	13
4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	14
4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ	15
4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ	177
4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ	188

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	5
Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....	8
Хүснэгт 3. Автотээврийн зорчигч.....	8
Хүснэгт 4. Төмөр замын ачаа тээвэр.....	9
Хүснэгт 5. Төмөр замын зорчигч тээвэр.....	12
Хүснэгт 6. Агаарын тээврийн ачаа.....	13
Хүснэгт 7. Агаарын тээврийн зорчигч.....	14
Хүснэгт 8. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....	15
Хүснэгт 9. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....	16
Хүснэгт 10. Нислэг гүйцэтгэл.....	17

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	6
Зураг 2. Нийт экспорт.....	6
Зураг 3. Нийт импорт.....	6
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	7
Зураг 5. Олон улсад зорчигч.....	7
Зураг 6. Орон нутгийн зорчигч.....	7
Зураг 7. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	8
Зураг 8. Автотээврийн зорчигч.....	8
Зураг 9.Төмөр замын ачаа	9
Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	10
Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	10
Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	10
Зураг 13. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр,	11
Зураг 14. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	11
Зураг 15. Төмөр замын зорчигч тээвэр.....	12
Зураг 16. Төмөр замын зорчигч, хоногоор.....	12
Зураг 17. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	13
Зураг 18. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	13
Зураг 19. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	13
Зураг 20. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	14
Зураг 21. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	14
Зураг 22. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	15
Зураг 23. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар.....	16
Зураг 24. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	16
Зураг 25. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	17
Зураг 26. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	17

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл – 2026 оны 4 дүгээр сар

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ²

Хүснэгт 1



№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025 /өссөн дүн/
				5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	7,407.7	33,823.9	10,466.3	51,154.1	51.2%
		Төмөр зам	мян.тн	3,732.5	17,329.7	5,365.4	25,557.7	47.5%
		Агаар	мян.тн	0.9	3.8	0.0	2.9	-24.2%
		Нийт ачаа	мян.тн	11,141.1	51,157.4	15,831.7	76,714.7	50.0%
2	Дамжин өнгөрсөн ачаа	Төмөр зам	мян.тн	524.9	2,413.9	502.5	2,411.9	-0.1%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	917.8	4,535.2	1,095.7	5,133.5	13.2%
		Автотээвэр	мян.тн	7,013.9	32,394.4	10,000.2	49,533.5	52.9%
		Нийт	мян.тн	7,931.7	36,929.6	11,095.9	54,667.0	48.0%
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	281.7	1,448.4	342.5	1,892.8	30.7%
		Автотээвэр	мян.тн	393.8	1,429.5	466.1	1,620.6	13.4%
		Нийт	мян.тн	675.5	2,877.9	808.6	3,513.4	22.1%
5	Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	2,008.1	8,932.2	3,424.7	16,119.5	80.5%
		Агаар	мян.тн	0.9	3.8	0.0	2.9	-24.2%
		Нийт	мян.тн	2,009.0	8,936.0	3,424.7	16,122.4	80.4%
6	Ачаа эргэлт	Автотээвэр	сая тн.км	1,121.9	5,135.0	1,501.8	7,248.1	41.2%
		Төмөр зам	сая тн.км	1,811.8	8,730.2	2,306.5	10,951.2	25.4%
		Агаар	сая.тн.км	1.9	9.6	2.3	11.8	22.7%
		Нийт	сая тн.км	2,935.6	13,874.8	3,810.6	18,211.1	31.3%
7	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	15,318.2	69,252.6	19,821.2	88,135.5	27.3%
		Төмөр зам	мян.хүн	144.5	688.6	144.9	665.9	-3.3%
		Агаар	мян.хүн	176.4	813.0	189.2	889.6	9.4%
		Нийт зорчигч	мян.хүн	15,639.1	70,754.1	20,155.3	89,691.0	26.8%
8	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	23.4	119.9	19.4	102.6	-14.4%
		Төмөр зам	мян.хүн	5.2	15.1	3.0	12.1	-19.6%
		Агаар	мян.хүн	140.6	644.2	155.1	725.9	12.7%
		Нийт	мян.хүн	169.2	779.1	158.1	840.7	7.9%
9	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	124.8	629.8	129.6	641.0	1.8%
		Төмөр зам	мян.хүн	139.3	673.5	141.9	653.8	-2.9%
		Агаар	мян.хүн	35.8	168.7	34.1	163.6	-3.0%
		Нийт	мян.хүн	299.9	1,472.1	305.7	1,458.4	-0.9%
10	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	15,170.0	68,502.9	19,672.2	87,391.9	27.6%
11	Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн.км	137.7	676.5	135.7	673.9	-0.4%
		Төмөр зам	сая хүн.км	58.3	288.5	59.9	285.4	-1.1%
		Агаар	сая хүн.км	374.3	2,034.6	406.7	2,133.7	4.9%
		Нийт	сая хүн.км	570.3	2,999.6	602.3	3,093.0	3.1%
12	Агаарын тээврийн нислэгийн тоо	Олон улсын хөөрөлт, буултын тоо	ш	1,112.0	4,855.0	1,207.0	5,483.0	12.9%
		Орон нутгийн хөөрөлт, буултын тоо	ш	892.0	3,770.0	1,030.0	3,884.0	3.0%
		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	6,605.0	31,106.0	7,801.0	37,133.0	19.4%

² Зам, тээврийн салбарын 2026 оны нэгдүгээр улирлын статистикийн мэдээг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр гаргав.

1.1. АЧАА ТЭЭВЭР


Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2026 оны 5 дугаар сард 15.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 42.1%-аар өссөн. Харин 2026 оны өссөн дүнгээр нийт 76.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.0%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2026 оны 5 дугаар сард 10.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.3 хувиар өссөн байна. Үүнээс экспортод 10.0 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 42.6%-аар өссөн бол импортоор 466.1 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 18.3%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин 2026 оны өссөн дүнгээр автотээврээр нийт 51.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.2%-аар өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2026 оны 5 дугаар сард 5.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.8%-аар өссөн байна. Харин 2026 оны өссөн дүнгээр нийт 25.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.
- Агаарын тээврээр оны эхнээс өссөн дүнгээр нийт 2.9 мянган тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.2%-аар буурсан байна.



Экспортоор 2026 оны эхний 5 сард 54.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.0%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 5.1 сая тонн тээвэрлэсэн нь 13.2%-аар, автотээврээр 49.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 52.9%-аар тус тус өссөн байна. Нийт экспортын дүнд автотээврийн ачаа 91%-ийг, төмөр замын ачаа 9%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2026 оны эхний 5 сард нийт 3.5 сая тонн болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.1%-аар өссөн. Үүнээс төмөр замаар 1.9 сая тонн ачаа импортолсон нь 30.7%-аар, автотээврээр 1.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 13.4%-аар тус тус өссөн байна. Импортын тээврийн 54%-ийг төмөр замаар, 46%-ийг автотээврээр тээсэн байна. /Зураг 3/





1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2026 оны 5 дугаар сард 20.2 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны 5 дугаар сартай харьцуулахад 28.9%-аар өссөн. Өссөн дүнгээр 89.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 26.8%-аар өсжээ.

- Автотээврээр 2026 оны 5 дугаар сард 19.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.4%-аар өссөн байна. Үүнээс орон нутагт 129.6 мянган зорчигч (+3.9%), олон улсад 19.4 мянган зорчигч (-17.1%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 19.7 сая зорчигч (+29.7%) тус тус зорчсон байна. Өссөн дүнгээр нийт 88.1 сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.3%-аар өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2026 оны 5 дугаар сард 144.9 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр нийт 665.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 3.32%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 12.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 19.6%-аар өссөн боловч орон нутагт 653.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 2.9%-аар буурчээ.
- Агаарын тээврээр 2026 оны 5 дугаар сард нийт 189.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.3%-аар өссөн байна. Өссөн дүнгээр нийт 889.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 9.4%-аар өссөн байна.


Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн



Олон улсад нийт 840.7 мянган зорчигч (+7.9%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 725.9 мянган зорчигч (+12.7%), автотээврээр 102.6 мянган зорчигч (-14.4%), төмөр замаар 12.1 мянган зорчигч (-19.6%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 86%, автотээвэр 12%, төмөр зам 2%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 5/

Орон нутагт нийт 1.5 сая зорчигч(-0.9%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 641.0 мянган зорчигч (+1.8%), төмөр замаар 653.8 мянган зорчигч (-2.9%), агаарын тээврээр 163.6 мянган зорчигч (-3.0%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 44%, төмөр зам 45%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутгийн зорчигч



БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА

2026 оны эхний 5 сард авто замаар 51.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 54%-аар өслөө.


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Хүснэгт 2
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	Өсөлт бууралтын % 2026/2025 /Өссөн дүн/
Нийт ачаа	мян.тн	7,407.7	33,823.9	10,466.3	51,154.1	51.2%
Импорт	мян.тн	393.8	1,429.5	466.1	1,620.6	13.4%
Экспорт	мян.тн	7,013.9	32,394.4	10,000.2	49,533.5	52.9%
Ачаа эргэлт	сая тн.км	1,121.9	5,135.0	1,501.8	7,248.1	41.2%

2026 оны 5 дугаар сард автотээврээр 10.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.2 хувиар өссөн байна. Үүнээс экспортод 10.0 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 52.9%-аар өссөн бол импортоор 466.1 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 13.4%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин 2026 оны өссөн дүнгээр автотээврээр нийт 51.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.2%-аар өссөн байна.

Ачаа эргэлт 2026 оны 5 дугаар сард 1,501.8 сая тонн.км болсон нь өмнөх оны мөн үеэс 33.9%-аар өссөн байна. Харин 2026 оны өссөн дүнгээр 7,248.1 сая тонн.км болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.2%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Ачаа тээврийн 97%-ийг экспортын ачаа, 3%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа 99.9% эзэлж байгаа бол үүнээс нүүрс 96.9%-ийг эзэлж байна. /Зураг 7/


2026 оны 5 дугаар сард авто замаар 9.7 сая тонн нүүрс экспортод гарсан. Харин өссөн дүнгээр 48.1 сая тонн нүүрс автозамаар экспортод гарчээ.



2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Хүснэгт 3
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	Өсөлт бууралтын % 2026/2025 /Өссөн дүн/
Нийт зорчигч	хүн	15,318,158	69,252,582	19,821,190	88,135,500	27.3%
Олон улсад	хүн	23,420	119,860	19,420	102,618	-14.4%
Орон нутагт	хүн	124,750	629,843	129,611	640,956	1.8%
Хот доторх нийтийн тээвэр	хүн	15,169,988	68,502,879	19,672,159	87,391,926	27.6%
Зорчигч эргэлт	сая хүн.км	137.7	676.5	135.7	673.9	-0.4%

Зураг 8. Зорчигч тээвэр



Автотээврээр 2026 оны 5 дугаар сард 19.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.4%-аар өссөн байна. Үүнээс орон нутагт 129.6 мянган зорчигч (+3.9%), олон улсад 19.4 мянган зорчигч (-17.1%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 19.7 сая зорчигч (+29.4%) тус тус зорчсон байна.

Өссөн дүнгээр нийт 88.1 сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.3%-аар өссөн байна.

Автотээврийн зорчигчийн 99.2%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 0.7%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.1%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 8/

БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР


3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА

Төмөр замын тээврээр 2026 оны эхний 5 сард нийт 25.6 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.5%-аар өслөө.


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Хүснэгт 4
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	бууралты % 2026/2025 /өссөн дүн/
Ачаа тээвэрлэлт	<i>мян.тн</i>	3,732.5	17,329.7	5,365.4	25,557.7	47.5%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	2,611.5	13,369.3	2,897.2	14,807.2	10.8%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	383.2	1,157.6	1,318.5	5,852.6	405.6%
"Монголиантранс Ложистик" ХХТ	<i>мян.тн</i>	359.0	1,605.3	359.5	1,661.0	3.5%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>	240.5	501.8	790.2	3,236.9	545.1%
Дотоодын ачаа	<i>мян.тн</i>	2,008.1	8,932.2	3,424.7	16,119.5	80.5%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	887.1	4,971.8	956.5	5,368.9	8.0%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	383.2	1,157.6	1,318.5	5,852.6	405.6%
"Монголиантранс Ложистик" ХХТ	<i>мян.тн</i>	359.0	1,605.3	359.5	1,661.0	3.5%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>	240.5	501.8	790.2	3,236.9	545.1%
Импорт ачаа	<i>мян.тн</i>	281.7	1,448.4	342.5	1,892.8	30.7%
БНХАУ-аас	<i>мян.тн</i>	79.7	361.0	69.9	529.2	46.6%
ОХУ-руу	<i>мян.тн</i>	202.0	1,087.4	272.6	1,363.7	25.4%
Экспорт ачаа	<i>мян.тн</i>	917.8	4,535.2	1,095.7	5,133.5	13.2%
БНХАУ-руу	<i>мян.тн</i>	900.7	4,466.6	1,086.1	5,078.7	13.7%
ОХУ-руу	<i>мян.тн</i>	17.1	68.6	9.6	54.9	-20.0%
Дамжин өнгөрөх ачаа	<i>мян.тн</i>	524.9	2,413.9	502.5	2,411.9	-0.1%
Ачаа эргэлт	<i>сая.тн-км</i>	1,811.8	8,730.2	2,306.5	10,951.2	25.4%

Төмөр замын тээврээр 2026 оны 5 дугаар сард 5.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.8%-аар өссөн байна. Харин 2026 оны өссөн дүнгээр нийт 25.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.5%-аар өссөн үзүүлэлттэй байна. Тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл дотоодын ачаа 16.1 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 80.5%-аар, импортын ачаа 1.9 сая тонн болж 30.7%-аар, экспортын ачаа 5.1 сая тонн болж 13.2%-аар тус тус өссөн бол, дамжин өнгөрөх ачаа 2.4 сая тонн болж 0.1%-аар буурсан байна. /Хүснэгт 4/

Зураг 9. Төмөр замын ачаа, мян.тн




Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь




2026 оны өссөн дүнгээр нийт ачаа тээврийн 14.8 сая тонн буюу 58%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 5.9 сая тонн буюу 23%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 3.2 сая тонн ачаа буюу нийт ачааны 13%-ийг "Монголиантранс Лайн" ХХК, 1.7 сая тонн буюу 6%-ийг "Монголиантранс Ложистик" ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 10/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл 16.1 сая тонн буюу 63%-ийг дотоодын ачаа, 5.1 сая тонн буюу 20%-ийг экспортын ачаа, 2.4 сая тонн буюу 10%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 1.9 сая тонн буюу 7%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 11/

Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл




Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь



Дотоодод тээвэрлэсэн 16.1 сая тонн ачааны 5.4 сая тонн ачаа буюу 33%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 5.8 сая тонн буюу 37%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 1.7 сая тонн ачаа буюу 10%-ийг "Монголиантранс Ложистик" ХХК, 3.2 сая тонн буюу 20%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 12/


Зураг 13. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2026.05.31



Төмөр замын байгууллагуудаар өдөр бүр тээвэрлэсэн ачааны хэмжээг төрлөөр нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос оруулав. 2026 оны эхний 5 сарын байдлаар өдөрт дундажаар орон нутгийн ачаа 106.8 мянга, экспортын ачаа 34.0 мянга, дамжин өнгөрсөн ачаа 16.0 мянга, импортод дундажаар 12.5 мянган ачаа тээвэрлэсэн байна. /Зураг 13/

Төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг 14/


Зураг 14 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор



3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Хүснэгт 5
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	Өсөлт бууралтын % 2026/2025 /Өссөн дүн/
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	144.5	688.6	144.9	665.9	-3.3%
Олон улс	мян.хүн	5.2	15.1	3.0	12.1	-19.6%
Орон нутаг	мян.хүн	139.3	673.5	141.9	653.8	-2.9%
Зорчигч эргэлт	сая хүн.км	58.3	288.5	59.9	285.4	-1.1%


Зураг 15. Төмөр замын зорчигч тээвэр



2026 оны 5 дугаар сард 144.9 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр нийт 665.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 3.3%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 12.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 19.6%-аар буурсан бол орон нутагт 653.8 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 2.9%-аар буурчээ.

Зорчигч эргэлт 5 дугаар сард 59.9 сая хүн км болсон нь өмнөх оны 5 дугаар сараас 2.7%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр 285.4 сая хүн км болсон нь өмнөх оны мөн үеэс 1.1%-аар буурчээ. /Зураг 15/

Зураг 16. Төмөр замын зорчигч, хоногоор




2025.01.01-2026.05.31-ний өдрүүдэд Улаанбаатар төмөр замаар зорчсон зорчигчийн тоог хоногоор нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос нэгтгэн гаргав. 2026 оны 5 сарын байдлаар төмөр замаар хоногт дундажаар 4.4 мянган зорчигч зорчиж байна. /Зураг 16/

БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР

4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025 /өссөн дүн/
			5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа, шуудан тээвэр	тн	883.3	3,813.5		2,891.3	-24.2%
2	олон улсад	тн	879.1	3,796.9		2,874.4	-24.3%
3	орон нутагт	тн	4.2	16.7		16.9	1.6%
4	Нийт ачаа	тн	869.2	3,733.2		2,830.8	-24.2%
5	олон улсад	тн	865.0	3,716.7		2,813.9	-24.3%
6	орон нутагт	тн	4.2	16.5		16.9	2.9%
7	Нийт шуудан	тн	14.1	80.4		60.5	-24.7%
8	олон улсад	тн	14.1	80.1		60.5	-24.5%
9	орон нутагт	тн		0.2		0.0	-95.5%
10	Ачаа, шуудан эргэлт	мян.тн-км	1,895.6	9,613.6	2,337.8	11,791.8	22.7%
11	олон улсад	мян.тн-км	1,893.4	9,602.8	2,336.5	11,781.1	22.7%
12	орон нутагт	мян.тн-км	2.2	10.8	1.3	10.7	-0.2%




Агаарын тээврээр 2026 оны эхний 5 дугаар сард 2.9 мянган тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.2%-аар буурсан байна. Үүнээс ачаа 2.9 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 24.3%-аар, шуудан 16.9 тонн болж 1.6%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 17/

Олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 2.9 мянган тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 24.2%-аар буурсан бол орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 16.9 тонн болж өмнөх оны мөн үеэс 1.6%-аар өссөн байна. /Зураг 18/

Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.4%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.6%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 98%-ийг ачаа эзэлж байгаа бол 2%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2026 оны эхний 5 сард 11.8 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 22.7%-аар өсжээ.



Зураг 19. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар




4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Агаарын тээврээр 2026 оны эхний 5 сард нийт 889.6 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 9.4%-аар өслөө.

Хүснэгт 7

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025 /өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
Нийт зорчигч	хүн	176,409	812,963	189,237	889,562.0	9.4%
Олон улсад	хүн	140,592	644,235.0	155,093	725,943.0	12.7%
Орон нутагт	хүн	35,817	168,728	34,144	163,619.0	-3.0%
Зорчигч эргэлт	мян.хүн км	374,339.8	2,034,580.0	406,718.0	2,133,740.7	4.9%
Олон улсад	мян.хүн км	355,671.1	1,940,324.6	386,329.0	2,039,817.4	5.1%
Орон нутагт	мян.хүн км	18,668.7	94,255.4	20,389.0	93,923.3	-0.4%




2026 оны 5 дугаар сард агаарын тээврээр нийт 189.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.3%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 155.1 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 10.3%-аар өссөн бол орон нутагт 34.9 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 4.7%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Өссөн дүнгээр нийт 889.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 9.4%-аар өссөн байна. /Хүснэгт 7/

Зорчигч эргэлт 2026 оны 5 дугаар сард 406.7 сая хүн км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.6%-аар өсжээ. Эхний 5 сар буюу өссөн дүнгээр 2,133.7 сая хүн км болж өмнөх оны мөн үеэс 4.9%-аар өссөн байна.

Зураг 21. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар



Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна./Зураг 22/

4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 8

№	Үзүүлэлт	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025 /өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Олон улсад					
2	чиглэл Сөүл	42,430	189,941.0	46,330	217,300.0	14.4%
3	Бээжин	24,600	105,919.0	25,898	116,139.0	9.6%
4	Токио	12,915	54,792.0	15,879	66,457.0	21.3%
5	Истанбул	12,801	50,245.0	11,754	49,941.0	-0.6%
6	ХонКонг	8,292	40,607.0	8,051	42,814.0	5.4%
7	Хөх хот	3,297	21,183.0	7,270	36,389.0	71.8%
8	Франкфурт	6,050	26,982.0	5,729	30,375.0	12.6%
9	Фукуок		19,026.0	0	17,697.0	-7.0%
10	Санья/Хайнань	1,941	13,722.0	2,077	18,389.0	34.0%
11	Эрээн			4,388	18,178.0	
12	Бангкок		13,558.0		12,079.0	-10.9%
13	Сингапур		0.0	0	8,405.0	
14	Пукет		9,405.0		8,397.0	-10.7%
15	Шанхай			4,565	12,157.0	
16	Алмата	2,733	9,751.0	2,510	9,544.0	-2.1%
17	Хо Ши Мин		11,068.0		6,348.0	-42.6%
18	Хайлаар/Хөлөнбуйр	1,535	2,629.0	1,484	6,571.0	149.9%
19	Эрхүү	1,303	6,123.0	1,465	6,465.0	5.6%
20	Хайкоу/Хайнань	735	5,522.0	1,075	5,552.0	0.5%


2026 оны эхний 5 сарын байдлаар олон улсын нислэгээр нийт 725.9 мянган зорчигч тээвэрлэсэн нь 2025 оны мөн үеээс 12.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Чиглэлээр авч үзвэл Сөүл хотын чиглэл хамгийн өндөр зорчигчтой хэвээр байгаа бөгөөд 2026 оны эхний 5 сард 217.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 14.4%-аар өссөн байна. Мөн Бээжин чиглэлд 116.1 мянган зорчигч тээвэрлэж 9.6%-аар, Токио чиглэлд 66.5 мянган зорчигч зорчиж 21.3%-аар тус тус өссөн байна.

Европын чиглэлээс Франкфурт чиглэлд зорчигчийн урсгал 12.6%-аар өсч, 30.4 мянгад хүрсэн бол Истанбул чиглэлд 49.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.6%-аар буурсан үзүүлэлттэй байна.


Зүүн болон Зүүн өмнөд Азийн аялал жуулчлалын чиглэлүүдээс ХонгКонг чиглэл 5.4%-аар өсөж, 42.8 мянган зорчигч тээвэрлэсэн бол Бангкок (-10.9%), Пукет (-10.7%), Хо Ши Мин (-42.6%) чиглэлүүдэд зорчигчийн тоо бууралттай байна. Харин Хөх хот чиглэлд зорчигчийн тоо 71.8%-аар, Санья/Хайнань чиглэлд 34.0%-аар тус тус өссөн байна. Нөгөө талаас Красноярск (-33.2%), Эрхүү (+5.6%), Алмата (-2.1%) зэрэг зарим чиглэлүүдэд зорчигчид зорчсон байна.

Зураг 22. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



Дээрх графикт 2026 онд хамгийн их зорчигч зорчсон 20 хотуудыг харуулав. /Зураг 22/

Зураг 23. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар



Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл – 2026 оны 4 дүгээр сар


2026 оны эхний 5 сарын байдлаар олон улсын нислэгээр зорчсон нийт зорчигчдын 45.2% буюу 328.3 мянган зорчигч үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр зорчсон байна. “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 92.5 мянган зорчигч (57.3%), “Air China” компанийн нислэгээр 77.1 мянган зорчигч (22.3%), “Aero Mongolia” ХХК-ийн нислэгээр 50.6 мянган зорчигч (22.3%), “Korean Air” компанийн нислэгээр 58.7 мянган зорчигч (1.3%), “Turkish Airlines”-ийн нислэгээр 30.9 мянга (5.9%), “Jeju Air”-ийн нислэгээр 27.9 мянга (13.6%), “Asiana Airlines”-ийн нислэгээр 15.6 мянга (23.7%), “Juneyao Air” 5.4 мянга (16.2%), “China United Airlines” 19.5 мянга, “IRAERO” 6.5 мянга (9.0%), “VietJet Air” 2.3 мянга (-70.8%), бусад агаарын тээвэрлэгчдийн нислэгээр 12.3 мянган зорчигч тус тус олон улсад зорчсон байна. /Зураг 23/

4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 9

№	Үзүүлэлт	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026/2025 /өссөн дүн/
		5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	
1	Орон нутагт зорчигч тээвэр	35,817	168,728	34,144	163,619.0	-3.0%
2	чиглэл Оюутолгой	30,647	146,550.0	27,185	137,032.0	-6.5%
3	Ховд	1,579	6,649.0	1,951	7,335.0	10.3%
4	Өлгий	1,186	5,447.0	1,270	5,556.0	2.0%
5	Улаангом	556	2,363.0	496	2,538.0	7.4%
6	Улиастай	542	2,454.0	539	2,676.0	9.0%
7	Мөрөн	559	2,489.0	635	2,728.0	9.6%
8	Алтай	639	2,662.0	484	2,221.0	-16.6%
9	Баянхонгор		0.0	524	2,322.0	
10	Бусад	109	114.0	1,060	1,066.0	835.1%

Зураг 24. Орон нутгийн зорчигч, чиглэлээр




2026 оны 5 дугаар сард орон нутагт 34.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7%-аар буурсан байна.

Харин оны эхнээс өссөн дүнгээр 163.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0%-аар буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү бууралтад Оюутолгой чиглэлд 137.0 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 6.5%-аар буурсан нь голлон нөлөөлжээ. /Хүснэгт 9/

Орон нутагт зорчигчдын 65% буюу 107.0 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 22% буюу 35.56 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 13% буюу 20.8 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. Орон нутагт “МИАТ” ХХК-ийн зорчигч 4.5%-аар, “Аэро Монголиа” ХХК зорчигч 6.4%-аар буурсан бол “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 11.4%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 25/

Зураг 25. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	2025 он		2026 он		Хүснэгт 10
	5 дугаар сар	Өссөн дүн	5 дугаар сар	Өссөн дүн	Өсөлт бууралтын % 2026/2025 /өссөн дүн/
Нийт нислэгийн тоо	8,609	39,731.0	10,038	46,500.0	17.0%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	6,605	31,106.0	7,801	37,133.0	19.4%
Хөөрөлт, буулт	2,004	8,625.0	2,237	9,367.0	8.6%
Олон улсын хөөрөлт, буулт	1,112	4,855.0	1,207	5,483.0	12.9%
Орон нутгийн хөөрөлт, буулт	892	3,770.0	1,030	3,884.0	3.0%

2026 оны 5 дугаар сард нийт нислэгийн тоо 10.0 мянга болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.6%-аар өссөн байна. Өссөн дүнгээр нийт нислэгийн тоо 46.5 мянга болж өмнөх оны мөн үеэс 17.0%-аар өссөн. Үүнээс олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 37.1 мянга болж 19.4%-аар, олон улсын хөөрөлт, буулт 5.5 мянга болж 12.9%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 3.9 мянга болж 3.0%-аар тус тус өссөн байна. /Зураг 26/

Зураг 26. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар

